

RENAC – ийн Дэлхийн Боловсролын Төсөл нь Монгол улсад Бие Даасан Эрчим Хүчээр Хангах Хөгжлийг Дэмжинэ



БЕРЛИН -14.12.2011 - Энэ долоо хоногт, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Гадаад Яамны тусламж дэмжлэгтэйгээр сэргээгдэх эрчим хүч болон эрчим хүчний үр өгөөжийн асуудал дээр ажилладаг Монгол Улсын эрчим хүчний салбарын улсын болон хувийн төлөөлөгчид Герман Улсын Сэргээгдэх Эрчим Хүчний Академийн (RENAC) боловсролын тусгай мэргэжилтнүүдтэй Улаанбаатар хотноо уулзаж сургалтад хэрэгцээтэй зүйлсээс гадна үр ашгийн дамжлагыг тодорхойлов. Хоёр талын яриа хэлэлцээр болон сургалт хичээлүүд нь RENAC – ийн нэг хэсэг болсон ололтонд хүрсэн "TREE – Сэргээгдэх Эрчим Хүч ба Үр Өгөөжийг Шилжүүлэх" Олон Улсын сургалтын хөтөлбөрийг бүрдүүлсэн ба энэ нь бие даасан эрчим хүчний нийлүүлэлтүүдийн хөгжлийг буй болгох тусгай мэргэжилтэнүүдийг сургах улс үндэстний стратегийг хөгжүүлэхэд туслах зорилготой юм.

Сэргээгдэх эрчим хүчнүүд нь Монгол улсад ойрын ирээдүйд илүү илүү чухал болно. Одоогийн хүн амын өсөлтөн дээр үндэслэвэл, Монгол улсын эрчим хүчний эрэлт хэрэгцээ нь 2020 он гэхэд 3 дахин өсөх хандлагыг харж магадгүй.

Ихэнх тохиолдолд, хөдөө орон нутгын бүсүүдийг төвийн цахилгааны системээс гаргаж байгаа цахилгаанаар хангах нь эдийн засгийн хэрэгжилтгүй болон техникийн талаасаа боломжгүй юм. Нөгөө талаасаа сэргээгдэх эрчим хүчний хэрэглээнүүд нь нүүдэлчний хэв маягт хамгийн тохиромжтой юм. Монгол улсад арвин хэмжээний нарны технологиуд, салхин эрчим хүч болон усан цахилгаан зэрэг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр байгаа. Сэргээгдэх эрчим хүчнээс бүрэн үр ашгийг олж авахын тулд, урьд нь хэрэгжиж буй системийг зөв зохистой хадгалж, арчилах мөн өөрийн цэвэрхэн эрчим хүчний салбарыг бүтээн байгуулах бөгөөд хамгийн том бэрхшээлүүдийн нэг нь зохистой үр чадвартай ажилтнуудыг сургах юм. Нэмэлт зүйлд нь тохиромжтой улс төрийн болон эдийн засгийн нөхцөл байдал бүрдэх юм.

Монгол – Германы харилцан яриа хэлэлцээр болон сургалт хичээлүүдийн үеэр, сэргээгдэх эрчим хүчний сургалтын хөтөлбөрийн шаардлага болон нөхцөл байдал ба тухайн орны боловсролын байгууллагууд дахь эрчим хүчний үр өгөөжийн талаархи асуудлууд үүнчлэн өөр мэргэжлийн багуудыг тодорхойлж, практик дээр хэрэгжүүлэх стратегийг буй болгосон. Үүнийг дагалдуулан RENAC нь дараагийн жил бодлого боловсруулагч нарт зориулсан сэргээгдэх эрчим хүчийг бүтээн байгуулахад хэрэгтэй үр нөлөөтэй бодлогын сүүрийг буй болгохтой холбогдсон цуврал сургалт хичээлүүдийг төлөвлөж байгаа үүний хажуугаар практик дээр технологийг хэрхэн хэрэгжүүлэхтэй холбогдсон сургалтуудыг хамтад нь хийх юм.

RENAC нь Берлинд (Герман) байрладаг ба өөрийн олон улсад танигдсан TREE боловсролын төслөөрөө дамжуулан сүүлийн 3 жилийн турш олон улсын хэмжээнд сэргээгдэх эрчим хүчний болон эрчим хүчний үр өгөөжийн салбарын хөгжлийг дэмжсээр байна. Өнөөдрийг хүртэл Германы Холбооны Улсын Байгаль Орчны Яамны дэмжлэгтэйгээр 50 иас дээш орны оролцогчтой сургалтуудыг явуулсан. Арваннэгдүгээр сард Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Гадаад Яам төслийн зохион байгуулалтыг авсан. Монгол улс нь төлөвлөсөн улсуудын жагсаалтанд багтсан ба үүнд Азербайжан, Казакстан, Орос, Тажикстан, Туркменстан болон Украин зэрэг бусад улсуудтай хамт орсон байна. TREE төсөл нь аль хэдийн улсдаа мөн олон улсын хэмжээнд олон шагналыг авч ололт амжилтанд хүрсэн.

RENAC – ийн Тухай: RENAC нь Берлинд (Герман) байрладаг ба сэргээгдэх эрчим хүчний болон эрчим хүчний үр өгөөжийн мэргэжлийн боловсролтой холбоотой боловсрол болон сургалт мөн бусад үйлчилгээнүүдийн олон улсын хүргэгч юм. Өөрийн үйлчилгээнүүдийнхээ хүрээнд нээлттэй болон анги доторхи сургалтууд, e-сургалт, гуравдагч талуудын сургалтыг зохион бүтээхэд зөвлөж мөн дэмжих - үүнд хичээлийн хөтөлбөрийг бэлдэхээс сургалтын төвүүдийг суурьлуулах зэргийг багтаадаг.

Нэмэлт мэдээллүүд: www.renac.de ба www.tree-project.de

Хэвлэл мэдээлэлд зориулсан зураг: www.renac.de/en/press/images/

Холбоо барих:

RENAC AG, Аняа Хаупт, Утас: 0049 (0) 30 52 689 58 73, E-Mail: haupt@renac.de

Press Release

RENAC's global education project supports the development of sustainable energy supplies in Mongolia



Berlin, 14.12.2011 – This week, with the support of the German Federal Foreign Office, public and private representatives from Mongolia's energy sector dealing with renewable energy and energy efficiency met educational specialists from Germany's Renewables Academy (RENAC) in Ulaanbaatar to define training needs along the value chains. The bilateral talks and workshops formed part of RENAC's accomplished "TREE - Transfer Renewable Energy & Efficiency" international training program, whose aim is to develop national strategies for training specialists in the development of sustainable energy supplies.

Renewable energies will get more and more important in the near future in Mongolia. Using current estimates of population growth, Mongolia may experience a three-fold increase in energy demand by 2020. In the most cases, supplying rural areas with electricity from the centralized power system is neither economically feasible nor technically possible. At the same time renewable energy applications are most suitable for the nomadic lifestyle. Mongolia has abundant renewable energy resources for solar technologies, wind energy and hydropower. In order to benefit fully from renewable energies, to maintain already existing systems properly and to build up an own clean energy industry, one of the biggest challenges is the training of personnel with appropriate skills. In addition suitable political and economic conditions must be created.

During the Mongolian-German talks and workshops, the requirements and conditions for a training program on renewable energy and energy efficiency issues in the country's educational institutions and for different professional groups were defined, and strategies developed for their implementation in practice. To follow this up, RENAC is planning a series of training courses for policy makers, to be held next year, on creating effective policy frameworks for the development of renewable energies, together with other courses dealing with the implementation of the technologies in practice.

RENAC, based in Berlin (Germany), has already been supporting the development of the renewable energy and energy efficiency sector on an international scale over the last 3 years through its internationally recognized TREE education project. To date, with the support of the German Federal Environment Ministry, courses have been undertaken with participants from more than 50 countries. In November the German Federal Foreign Office took over promotion of the project. Mongolia has been included in the list of target countries, together with others such as Azerbaijan, Kazakhstan, Russia, Tajikistan, Turkmenistan and Ukraine. The TREE project has already won acclaim, both nationally and internationally, through a number of awards.

About RENAC: RENAC, based in Berlin, is an international provider of education and training and other services related to professional education in renewable energies and energy efficiency. Its range of services includes open and in-house courses, e-learning, consultancy and support of third parties in course design - from drawing up of curricula through to setting up training centers.

Further Information: www.renac.de and www.tree-project.de

Image for press use: www.renac.de/en/press/images/

Press Contact:

RENAC AG, Anja Haupt, Schönhauser Allee 10-11, 10119 Berlin, Germany

Tel.: 0049 (0) 30 52 689 58 73, E-Mail: haupt@renac.de

Supported by